

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

2020 оны 12-р сарын 01-ний өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын ээлжит хоёрдугаар хуралдааныг цахимаар хуралдуулахаар шийдвэрлэн аймгийн ИТХ-ын ээлжит хоёрдугаар хуралдаан 12-р сарын 3-ны өдөр цахимаар хуралдаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо байгуулж, ажиллах журам, эрхлэх асуудал, бүрэлдэхүүнийг батлах тухай, аймгийн 2020 оны орон нутгийн төсөвт зохицуулалт хийж, тодотгон батлах тухай, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, аймаг хөгжүүлэх 2021 оны төлөвлөгөөг батлах тухай, аймгийн 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог батлах тухай, аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн төслийн тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Засаг даргын 2017 оны 278 дугаар захирамжаар батласан “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу агентлаг, сумдын 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.

Улсын Онцгой комисс болон ОБЕГ-аас өгсөн үүрэг, албан даалгаварын хүрээнд аймгийн хэмжээнд бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын барилга байгууламжуудад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон бэлэн байдалд үзлэг шалгалт зохион байгуулж, заавар зөвлөгөө өгч, тухай бүр удирдах албан тушаалтанд үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 137 дугаар тушаалын дагуу аймгийн хэмжээнд Шуурхай штаб, хариу арга хэмжээний 10 багийг 148 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан мэргэшил арга зүйн удирдлагаар ханган, бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд зориулан аж ахуй нэгж, байгууллагаас өгсөн мөнгөн хандив, эд материалын тусламжаар болзошгүй эрсдэлийн үед шаардагдах амны хаалт, нэг удаагийн хувцас болон бусад шаардлагатай эд зүйлийн нөөцийг бүрдүүлэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, халдварын тархалтыг зогсоох зорилгоор 19 сумдад нийт 35 сургуулийн дотуур байр, зочид буудлыг бэлэн байдалд байлгаж байна.

Бүх шатны боловсролын байгууллага, олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, соёл, урлаг, спортын арга хэмжээ, сургалт, семинар, хурал зөвлөгөөн, баар, ресторан, цай, хоолны газар, шашны үйл ажиллагаа, интернэт тоглоом, караоке, цахим тоглоомын газар, спорт заал, зочид буудал, амралт, сувиллын газар, фитнес, үсчин, хөлсөөр хүн тээвэр хийх үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан Онцгой байдлын газар нийт 240 гаруй байгууллагад хяналт тавьж ажиллахад зөрчил дутагдал илрээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэлээр Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаатай холбогдуулан Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын болон орон нутгийн чанартай авто замын хөдөлгөөнийг 6 удаа түр хугацаагаар хязгаарлаж аймгийн 19 сумын хэмжээнд давхардсан тоогоор 250 гаруй пост, 6900 гаруй албан хаагч, 700 гаруй техник хэрэгсэлтэйгээр аймаг, сумаас гарах, орох хүн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж ажиллаж байна.

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

/2020 оны 12-р сарын 27-ны өдрийн байдлаар/



**Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд
Татвар төлөлт**

2020 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт 1373.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 1374.5 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.1 хувиар, аймгийн төсөвт 6068.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 6800.0 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 112.1 хувиар тус тус хүлээгдэж буй гүйцэтгэлээр биелүүлж ажиллалаа.

Хөрөнгө оруулалт

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 42.481.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас орон нутагт эрх шилжсэн 19.953.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 14.645.0 сая төгрөг байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжихээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь 435.0 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжихээс гүйцэтгэл нь 2.322.0 сая төгрөг байна, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Орон нутгийн өмч

Орон нутгийн өмчит 68 төсөвт байгууллагад 456.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 7 төсөвт байгууллагад 48.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, 26 байгууллагад 756 нэр төрлийн 317.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Санхүүгийн хяналт

Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн үйл ажиллагаанд аудит хяналт шалгалтаар 3 төрлийн актаар 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, нөхөн олгуулах, хураан барагдуулахаар шийдвэрлэж, 1 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн хүрээнд 3 сумын үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалт хийж, Хайрхан сумын

Эрсдэлийн сантай холбоотой үүссэн асуудлыг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт.

Онцгой комиссын даргын баталсан удирдамжийн дагуу коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх “Амны хаалтаа зүүцгээ” нэгдсэн арга хэмжээг Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хүнсний дэлгүүр, зоогийн газар, баар, ресторан, зочид буудал, худалдааны төвүүд, дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, МСҮТөв, төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн нийт 18 мянга гаруй ажилтан, албан хаагч, 19 сумын Засаг дарга нарт үүрэг өгч 95000 гаруй иргэдэд 2 удаа зохион байгуулж заавар, зөвлөмжийг тараан мэдээлэл өгч, аж ахуйн нэгжийн ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, иргэд олон нийтийг амны хаалт /маск/ зүүхийг уриалж ажиллалаа.

Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолын дагуу харилцаа холбоо, эрчим хүч, ус, дулаанаар хангах, шатахуун түгээх станц, хүнсний худалдаа эрхэлдэг, аж ахуйн нэгж, байгууллага, эмнэлэг, эмийн сан, хэвлэл мэдээлэл, буян шашны 215 байгууллага, аж ахуйн нэгжүүд ажлын хэвийн горимоор, 43 байгууллага ажлын тусгай горимоор ажиллаж байна.

12-р сарын 07-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотоос Архангай аймгийн 7180 гаруй иргэдийг татан авах ажлыг аймаг, орон нутаг зохион байгуулан ажиллалаа.

Батцэнгэл суманд 11-р сарын 29-ний өдөр Улаанбаатар хотод батлагдсан тохиолдлын ойрын хавьталаас авсан PCR шинжилгээгээр 3 тохиолдол батлагдаж Улаанбаатар хотын Цэргийн төв эмнэлэгт зөөвөрлөн хүргэж эмчлүүлж байна.

Батцэнгэл сумын батлагдсан тохиолдлын ойрын хавьталын 75 хүн, 2-р хавьталын 855 хүнийг тандалт судалгаагаар тогтоож тусгай байр, гэрийн ажиглалтанд тусгаарлах арга хэмжээ авч PCR шинжилгээг ойрын хавьталын 74 хүнээс 3 удаа, дам хавьталын 855 хүнээс 2 удаа сорьц авч явуулын автолаборатори болон ЗӨСҮТ, ХӨСҮТ-д хүргүүлсэн. Нэмж батлагдсан тохиолдол одоогоор гараагүй байна. Тус хугацаанд нийт 3141 сорьцыг хүлээн авч PCR шинжилгээнд оруулсан байна. Сумын хэмжээнд нийт 19442 м² талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийсэн.

Мөн сумын хэмжээнд хатуу хөл хорио тогтоож аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газраас хяналт тавьж бусад сумдтай хиллэдэг төв зам болон гол замын хөдөлгөөнийг хязгаарлах чиглэлээр 4 постод нэг ээлжинд 8 төрийн алба хаагч, сумын төв тойрсон байнгын 3 нийт 7 постод 14 алба хаагч, 24 цагаар тасралтгүй, хөл хорионы дэглэм сахиулах иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, гудамж талбайд эргүүл хяналт шалгалтын чиглэлээр 2 чиглэлд 4 алба хаагч, 2 автомашинтайгаар тус тус үүрэг гүйцэтгэн хяналт шалгалт хийж ажилласан.

МХЕГ-ын даргын 2020 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах заавар”, 2020 оны 11-р сарын 19-ний өдөр батлагдсан “Гамшгаас хамгаалах мэргэжлийн болон цацрагийн хяналтын улсын албаны төлөвлөгөө”-ний дагуу шуурхай штабын бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар Эрдэнэбулган сумын хэмжээнд Хүнсний зах, Худалдааны төв, Хүнсний дэлгүүр, ШТС, Эрчим хүч, Эх голомтын илч ХХК, Ар-Ус ундарга ХХК-ийн гүний худаг, ус түгээх байрууд, бохир ус цэвэрлэх байгууламж болон боловсролын байгууллагууд, тусгаарлах байрууд зэрэг 453 объектыг хамруулан дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж мэдэгдлийг хүргүүлж, хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 144 иргэн, аж ахуй нэгжийн 43329 м², боловсролын 15 байгууллагын 45815 м², бусад 11 байгууллагын 8787 м² талбайд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл хийлгүүлж хяналт тавьж ажилласан.

Мөн Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж буй 43 эрүүл мэндийн байгууллагыг хамруулж дэмжлэгт хяналтыг хийж, Коронавируст халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, халдвар хамгааллын

дэглэмийг сахиулах, аюултай хог хаягдлыг зайлуулах талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч 42 заалт бүхий 35 зөвлөмжийг хүргүүлсэн.

Зорчигч үйлчилгээний төв, нийтийн тээврийн 101 автобусны цэвэрлэгээ, халдваргүйтгэл, нийтийн тээврээр ирсэн, явсан 1820 иргэний халдвар хамгааллын дэглэмийн байдалд 9 улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэй 3 ажлын хэсэг байнгын хяналт хийж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, 1592 зөвлөмжийг иргэдэд тараалаа.

Эрдэнэбулган, Ихтамир, Батцэнгэл сумдын 25 тусгаарлах байранд хяналт шалгалт хийж, 10 тусгаарлах байрны хоол үйлдвэрлэлийн ундны уснаас дээж авч аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулсан, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, цаашид шийдвэрлэх асуудлын талаар аймгийн Шуурхай штабт мэдээлэл хийж ажилласан.

Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж буй Нийтийн худалдааны төв, Хүнсний зах, бөөний төв, агуулах, хүнсний үйлдвэр, хүнсний дэлгүүр зэрэг давхардсан тоогоор 288 объектод хяналт тандалтыг хийж, 144 объектын 43329 м² талбайд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэлийг хийлгүүлж хяналт тавьж ажилласан. Шалгалтаар 31 нэр төрлийн 155 заалт бүхий зөвлөмж, 14 нэр төрлийн сэрэмжлүүлэг өгч, 861 зөрчил дутагдал илрүүлж, 543 дутагдлыг арилгуулж, 1 иргэнд 300000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 100% барагдуулж, хадгалалтын хугацаа дууссан, чанар аюулгүй байдлаа алдсан 11 нэр төрлийн 307 ширхэг 335960 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татуулсан байна.

Батцэнгэл суманд Коронавирусын халдвар гарсантай холбогдуулан голомтын эцсийн халдваргүйтгэлийг 70 айл өрх, 55 худалдаа үйлчилгээний газар, 20 албан байгууллагыг хамруулан 21467 м² талбайд хийлгүүлж, хяналт тавьж мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж халдвар хамгааллын дэглэмийг сахиулж ажилласан.

Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаалаар батласан удирдамж, Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/822, А/837, А/867, А/886 захирамжуудын хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтийг халдвараас сэргийлэх ажлын хүрээнд хүнсний дэлгүүр, зах, шатахуун түгээх станц, эмнэлгийн байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хяналт хийж, хүн хоорондын зай барих, масктай иргэдэд үйлчлэх, гар ариутгах, гар угаах, иргэдийг маск зүүх, шаардлагагүй тохиолдолд гадуур явахгүй байх талаар нийт 719 зөвлөмж, постер, санамж хуудсыг тарааснаас, цахимд-15, постер-75 байрлуулж, санамж хуудас 15 төрөл, 5 төрлийн 614 зөвлөмжийг тарааж мэдээ мэдээллийг түгээлээ.

2020 оны 11-р сард аймгийн хэмжээнд 437 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 127, хулгайлах гэмт хэрэг 175, иргэдийн өмчийн гэмт хэрэг 64, малын хулгайн гэмт хэрэг 99, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 26, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 109, гэмт хэргийн илрүүлэлт 48.3 хувьтай байна.

Нийт 26804 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 25990 иргэнд 856.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1445.6 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 47.4 хувьтай байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 12-р сард 3266130.8 төгрөгийн мөнгөн дүн бүхий 642 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 57.6, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 42.1 байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр худалдаа үйлчилгээний газрын тохирлын гэрчилгээ сунгуулах болон шинээр авах 18 хүсэлт хүлээн авч тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тохирлын гэрчилгээ шинээр авах-3, сунгуулах-15 нийт 18 хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэж стандартчилал, техникийн зохицуулалт мэдээллийн санг эрхлэх чиглэлээр 2 аж ахуй нэгжид 19 стандартын мэдээлэл лавлагааны үйлчилгээ үзүүлж 291400 төгрөгний стандартыг худалдан борлууллаа.

Мөн 17 аж ахуй нэгж, албан байгууллагын 17 усны тоолуур, үйлчилгээ эрхлэгч 5 аж ахуй нэгжийн /масс/ хэмжих хэрэгсэл, 4 өрхийн 4 цахилгаан хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийж баталгаажуулж гэрчилгээ олгосон байна.

Шүүхийн шинжилгээний алба 12-р сард криминалистикийн шинжилгээ 5, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 19, шүүх эмнэлгийн 19 шинжилгээ хийсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс 12-р сард дараах бүртгэлийг хийсэн байна.

Иргэний бүртгэл

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 187

Гэрлэлтийн бүртгэл - 24

Гэрлэлт цуцалсаны бүртгэл – 4

Эцэг тогтоосны бүртгэл - 0

Хүүхэд үрчлэлтийн бүртгэл - 3

Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 8

Нас баралтын бүртгэл - 34

Шинээр иргэний үнэмлэх олгосон - 96

Дахин олгосон – 92

Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан –182бүртгэл хийгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэл

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 28

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл – 45

Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл - 29

Газар эзэмших эрхийн анхны бүртгэл-136

Арилжааны гэрээ - 2

Худалдах худалдан авах гэрээ – 34

Бэлэглэлийн гэрээ – 8

Барьцааны эрхийн бүртгэл – 163

Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 5

Лавлагаа – 6

Бусад эрхийн бүртгэл – 15

Хуулийн этгээд

Шинээр бүртгүүлсэн – 10

Өөрчлөлт – 92

Тамганы хяналтын дугаар олгосон –10

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

Улс орон даяар зохион байгуулсан Боловсролын ерөнхий хуулийн хэлэлцүүлэгт аймгийн БСУГ, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн удирдлагууд, багш нар оролцов.

Архангай аймагт хүүхдийн цэцэрлэгийн 7675 хүүхдээс 5375 хүүхэд /70%/, бага боловсролын 9514 хүүхдээс 6548 хүүхэд /69%/, суурь боловсролын 6240 хүүхдээс 3977 хүүхэд /64%/, бүрэн дунд боловсролын 2977 хүүхдээс 1987 хүүхэд /67%/ теле хичээлийг тогтмол үзэж байгаа судалгаа гарсан байна. Аймгийн хэмжээнд теле хичээлд хамрагдалт 68%-тай байна.

Боловсролын үнэлгээний төвөөс “Үр дүнд суурилсан үнэлгээний арга зүй” сургалтыг 12-р сарын 23, 24-ны өдөр цахимаар зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежерүүд оролцлоо.

Соёл, урлаг

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимд монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 70, хүүхдийн уншлагын танхимд хүүхэд, өсвөр насныханд зориулсан уран зохиолын 32 шинэ номын үзэсгэлэн гаргаж, үндсэн фондын 410 нэрийн 1700 ширхэг номыг шивж, бар коджуулсан байна.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэгдүүлэх бэлэн байдлыг хангах зорилгоор 162.9 сая

төгрөгийн тоног төхөөрөмжийн тооцоо судалгаа гарган Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг дарга, аймгийн Онцгой комисст хүргүүлснээр аймгийн Засаг даргын 2020 оны А/858 дугаар захирамжаар хүчилтөрөгч өтгөрүүлэгч 80, амьсгалын аппарат 2, дуслын автомат шахуурга 3, тариурын автомат шахуурга 8, халуун хэмжигч 80, пульсоксиметр 80 ширхэгийг нийлүүлэх гэрээ байгуулж, халуун хэмжигч 80, пульсоксиметр 80, дуслын автомат шахуураг 2 ширхэг нийлүүлснийг эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.

“Эрт илрүүлэг, эрүүл мэндийн төв”, Эрдэнэмандал сумын Сум дундын эмнэлгийн барилга ашиглалтанд орсон.

Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу 12-р сарын 07-оос 17-ны өдрүүдэд зорчилт хөдөлгөөн хийгдэж, хувийн унаа болон хот хоорондын автобусаар аймагтаа ирсэн 5843 хүнийг сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд гэрийн ажиглалтанд хянасан, гэрийн ажиглалтанд нийт 2816 хүн байна.

Сумын эрүүл мэндийн төвүүдтэй 5 удаа Gotomeeting-ээр холбогдож, коронавирүст халдварын нөхцөл байдал, бэлэн байдал, хавьтал тандалтын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нийт 110 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.

Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, лабораторийн урвалж оношилур, ариутгал халдваргүйтгэлийн нөөцийн бүрдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар 101.2 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, аймгийн Засаг даргын 2020 оны А/879 дүгээр захирамжаар 98 сая төгрөгний 7000 ширхэг оношлуурыг худалдан авч хангалт хийсэн.

“Коронавирусын халдварын сэргийлэлт, хяналт, эмнэл зүйн менежмент” сэдэвт цахим сургалтад 274 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан, 16 модуль цуврал хичээлийг судаллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 12-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 959 иргэн бүртгэлтэй байгаагаас 479 эмэгтэй. Шинэ ажлын байр 1076 үүнээс байнгын ажлын байр 595, улирлын ажлын байр 69, түр ажлын байр 412 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 951, зуучлал 903 байна. 12-р сарын 20-ны байдлаар 185 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй-5, бага- 28, суурь-149, бүрэн дунд-595, техникийн болон мэргэжлийн анхан шатны-21, тусгай мэргэжлийн дунд-16, Дипломын бакалаврын-145 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар нийт 15.9 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112 хувиар биелүүлсэн. Давхардсан тоогоор 17 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 59.5 тэрбум төгрөг зарцуулж, улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1117.6 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүллээ.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

“Яг одоо” аяны хүрээнд үндэсний хэмжээнд боловсруулагдсан 21 ширхэг постер, 8 шторк, өөрсдийн бэлтгэж хийсэн 19 постер, 4 шторкыг цахим сүлжээнд 42.800 хүнд түгээснээр гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нь нэмэгдүүлсэн.

Мөн Гэр бүлийн боловсрол нэмэгдүүлэх ажлын хүрээнд 42 удаагийн цахим зөвлөгөөг бэлтгэн байгууллагын фейж хуудсаар түгээж, 11.2 мянган хүнд хүргэсэн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

12 сарын байдлаар малд бэлчээрээс олж идэх өвс бага, мал нэмэгдэл тэжээлд орсон өвс тэжээлийн хүрэлцээ муу, зах зээлийн үнэ өндөр байгаа, аймгийн нутгаар олон жилийн дундажаас -2,-3 градусаар хүйтэн, нийт нутгаар цасан бүрхүүл тогтсон нь зудын эрсдлийн улам бүр нэмэгдүүлж өвөлжилт хүндрэх шалтгаан болж байна.

12-р сарын 10-ны байдлаар гарсан зудын эрсдлийн мэдээгээр аймгийн нийт нутгийн 20 хувь гаруй хувьд нь нэн их эрсдэлтэй, 60 гаруй хувь нь их эрсдэлтэй, 15 гаруй хувь нь дунд эрсдэлтэй гарсан байна.

Аймгийн хэмжээнд 2020-2021 онд 6.3 сая толгой мал өвөлжиж хаваржихаас Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3 сумын 709 малчин өрхийн 73.2 мянган толгой мал, аймаг, орон нутгийн тусгай хэрэгцээний нөөц нутагт 2 сумын 71 малчин өрхийн 31.5 мянган толгой мал, Дорнод, Сүхбаатар, Төв, Булган, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын Гачуурт, 61 гарамд 75 малчин өрхийн 41.4 мянган толгой мал отроор өвөлжиж байна.

Баянхонгор аймгийн 19 сумаас манай аймгийн 13 суманд 169 өрхийн 59.7 мянган толгой мал, Өвөрхангай аймгаас 12 суманд 91 өрхийн 38 мянган толгой мал, Завхан, Хөвсгөл аймгуудын нутгаас 21 малчин өрхийн 11.4 мянган толгой мал үүнээс манай аймгийн зарим сумдын нутагт отроор өвөлжиж байна. Бусад малчдын хувьд сум орон нутагтаа отор нүүдэл хийн өвөлжиж байна.

Малчид өөрийн аймгийн болон Төв, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Увс зэрэг аймгуудын нутгаас малчдын түвшинд 51.4 мянган тн өвс, 8317 тн ногоон тэжээл, 1009 тн гар тэжээл, 12 тн үйлдвэрийн тэжээл, 579.6 тн давс хужир шүүг нөөцлөн авсан. Тэжээл бэлтгэл 66 орчим хувьтай, 11-р сарын дунд үеээс мал нэмэгдэл тэжээлд орсон. Нийт тэжээлийн 50-60 хувийг малчид хэрэглэсэн, сумын нөөц бүрдүүлэлт өвс 1291 тн байснаас 60 хувийг малчдадаа зарж борлуулсан. Одоогоор сумдын нөөцөд 588 тн өвс, 53 тн тэжээл байна.

Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолын дагуу аймгийн аюулгүй нөөцөд 325 тн өвс нөөцөлснөөс нөөцөд 100 тн өвс байна. Засгийн газрын нөөц сангаас аймагт хуваарилсан 200 сая төгрөгийг аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 19 суманд 9.5 сая, аймгийн нөөцөд 19.5 сая төгрөгийг хуваарилж аймаг, сумын аюулгүйн нөөц бүрдүүлэхээр болсон.

НҮБ-ын хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас өвөлжилт хүндэрсэн Эрдэнэмандал, Хайрхан, Өлзийт, Хашаат, Хотонт, Батцэнгэл, Өгийнуур сумдын эмзэг бүлгийн өрх толгойлсон олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, хонин толгойд шилжүүлснээр 60-300 толгой малтай 1 сумаас 16 өрхөд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн.

Газар тариалан

2020 оны намрын ургацаас Хөдөө аж ахуйг дэмжих сан болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлсэн хүнсний улаан буудайн урамшуулалд хамрагдах 12 иргэн, аж ахуйн нэгжийн 2247.7 тн улаан буудайд урамшуулал олгуулахаар холбогдох материал, судалгааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих санд хүргүүлээ.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

Сум дундын ойн анги, Эрдэнэбулган, Булган сумын ЗДТГ, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Булган сумын нөхөрлөлүүдийн холбоо ТББ, байгалийн нөөцийн хамтын менежентийн нөхөрлөлүүд хамтран ойн цэвэрлэгээний ажлыг 12-р сарын 23-наас 25-ны өдрүүдэд зохион байгуулж, 800 гаруй шоо метр түлээний модыг зах зээлийн үнээс 40-50 хувийн хямдралтайгаар Эрдэнэбулган сумын иргэдэд худалдаалсан байна.

Ойн цэвэрлэгээний ажил хийснээр ойн төлөв байдал сайжирч, эрүүлжих, нөхцөл бүрдэж, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчний аюул буурч, ойн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх талбай бэлтгэгдэж иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, нөхөрлөлийн гишүүдийн ойн байгалийн нөөцийн хамтын менежмент, ойн арчилгаа, цэвэрлэгээний ажил гүйцэтгэх технологи, аюулгүй ажиллагааны талаарх ойлголт мэдээлэл нэмэгдсэн байна.

Тэрхийн цагаан нуурын хойд болон урд эрэгт 2 газарт нийтийн сайжруулсан 00-той, хог хаягдал хаях нэгдсэн хогийн цэг бүхий дотоод гадаадын аялагчдад зориулсан отоглох цэг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Өгийнуурын урд эрэгт “Фамилипартнерс” ХХК нийтийн ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгийг тус тус байгуулсан байна. Мөн Өндөр-Улаан сумын Бэлхи багийн Тээлийн гүүрт улсын чанартай авто зам дагуу нийтийн ариун цэврийн байгууламжийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр “Бөөрөн дэлийн элс” ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан.

Хүнс, үйлдвэрлэл, үйлчилгээ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон аймгийн Онцгой комиссод хүнсний нөөцийн мэдээг 7 хоногт 2 удаа гаргаж өгч мэдээллээр ханган ажиллаж байна. Сүүлийн 7 хоногийн судалгаагаар мах 287 тн буюу 23 хоног, гурил 247.4 тн буюу 33 хоног, гоймон 36.9 тн буюу 3 хоног, будаа 81.3 тн буюу 21 хоног, сахар 56.4 тн буюу 23 хоног, ургамлын тос 21.3 тн буюу 12 хоног, давс 27 тн буюу 68 хоног, ундны ус 20.8 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 5.03 тн буюу 4 хоног, төмс 205.7 тн буюу 76 хоног, хүнсний ногоо 27 тн буюу 2 хоног, өндөг 0.75 тн буюу 13 хоногийн нөөцтэй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2020 оны А/225, А/379 дүгээр тушаалуудын дагуу хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээл тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэлд QR код олгож байгаа бөгөөд 12 сарын 25-ны байдлаар 380 тээвэрлэлтэнд захиалга үүсгэсэн QR код олгосон байна.

Барилга, дэд бүтэц

Архангай аймагт 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр 79 тэрбум 378.9 сая төгрөгийн өртөг бүхий 41 төсөл арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр 955.0 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ, БСШУС-ын сайдын багцын 1 тэрбум 703.6 сая төгрөгийн өртөг бүхий 22 төсөл арга хэмжээ, нийт 82 тэрбум 37.5 сая төгрөгийн өртөг бүхий 71 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээд ажиллалаа. 12-р сард Эрдэнэбулган сумын Сургалт, олон нийтийн мэдээллийн төв, Эрдэнэбулган сумын 25 метр цамхаг барих ажил, Мал эмнэлгийн барилга, Хотонт сумын Соёлын төвийн барилгыг тус тус байнгын ашиглалтанд хүлээн авсан байна.

2020 оны оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар 24 байршилд 4.75 га, өвөлжөө, хаваржааны дорх газрыг эзэмшүүлэхээр 49 байршилд 3.5 га, тариалангийн зориулалтаар давуу эрхээр 23 байршилд 636 га, тариалангийн зориулалтаар дуудлага худалдаагаар 4 байршилд 30 га, төсөвт байгууллагын хэрэгцээнд зориулан 26 байршилд 4.68 га, аялал жуулчлалын зориулалтаар 3 байршилд 3 га, эзэмшиж байгаа хашааны газрыг нь нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэхээр 85 байршилд 5.21 га, гэр бүлийн хэрэгцээнд зориулан шинээр эзэмшүүлэхээр 545 байршилд 23.4 га, иргэнд аж ахуйн зориулалтаар үнээр нь өмчлүүлэхээр 1 байршилд 0.06 га, төмс хүнсний ногооны зориулалтаар дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр 1 байршилд 1 га газрыг тус тус эзэмшүүлж, өмчлүүлээд байна.

19 сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг дээд шатны төлөвлөгөөтэй уялдуулан 14 төрлөөр боловсруулж, аймгийн хэмжээнд нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----